



**КОРОНАВИРУСТ (КОВИД-19) ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ, ХАЛДВАРЫН СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ ИЛЭРСЭН ҮЕД  
АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Төлөвлөгөөний зорилго:** Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/06 дугаар захирамжийн хүрээнд Коронавируст /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хийгдэх ажлууд                                                                                                                                                                                                                       | Авах арга хэмжээ                                                                                                                                | Хариуцах хэлтэс алба     |
|---|-------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|
| 1 | 1.1                     | Ажилтан, албан хаагч, иргэн, үйлчлүүлэгчдэд зориулан коронавируст (КОВИД-19) халдвараас урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаас гаргасан зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг зэргийг нүдэнд харагдахуйц газар байрлуулах | Хурлын танхим, албан тасалгаа, явган шат, ариун цэврийн өрөө                                                                                    | ЗУХ, ХАБЭААлба, Эмч      |
| 2 | 1.2                     | Байрны үүд хэсэгт ажилтан, алба хаагч, иргэн, үйлчлүүлэгчийн орох хөдөлгөөнд хяналт тавих ажилтан /баг/-г томилон тухайн ажилтныг амны хаалт, бээлий, нүүрний хаалтаар бүрэн хангах                                                  | Орох, гарах иргэдэд тавих хяналтыг сайжруулах                                                                                                   | ЗУХ, СБХ, ХАБЭААлба, Эмч |
| 3 | 1.3                     | Ажилтан, алба хаагч болон дотогш нэвтэрч байгаа хүний биеийн халууныг тогтмол хэмжих, халдвар хамгааллын дэглэм баримтлуулан амны хаалт зүүхийг шаардах, гар угаах, халдваргүйтгэх нөхцөлөөр бүрэн хангах                            | Биеийн халууныг тогтмол хэмжих                                                                                                                  | ЗУХ, СБХ, ХАБЭААлба Эмч  |
| 4 | 1.4                     | Байгууллага, аж ахуйн нэгжээр үйлчлүүлэхээр ирсэн иргэд, үйлчлүүлэгчдэд QR код уншуулах, амны хаалт зүүх шаардлага тавих ба дотогш нэвтрүүлэхээс зайлсхийх, холбогдох албан тушаалтанг дуудаж үйлчлэх                                | QR кодыг тогтмол уншуулах, үүдний харуулын ажилд тогтмол хяналт тавих                                                                           | Бүх хэлтэс албад         |
| 5 | 1.5                     | Ажлын байранд 14 хоног тутамд мананцар үүсгэгч ашиглан халдваргүйтгэл хийлгэж байх                                                                                                                                                   | 14 хоног тутамд ариутгал халдваргүйтгэл хийлгэх                                                                                                 | СБХ, ДХШХ, ХАБЭААлба     |
| 6 | 1.6                     | Ажлын байранд өдөр бүр цэвэрлэгээ хийж, хүний гар байнга хүрдэг хэсгүүдийг спиртен суурьтай халдваргүйжүүлэгч уусмалаар арчиж халдваргүйжүүлж байх                                                                                   | Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шатны бариул, унтраалга, цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгслийн гадаргууг арчиж халдваргүйжүүлэх | ЗУХ, Эмч, ХАБЭААлба      |

|    |     |                                   |                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                  |                          |
|----|-----|-----------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|
| 7  | 1.7 | 2. Халдвараас сэргийлэх чиглэлээр | Сэжигтэй тохиолдол илэрсэн үед эрүүл мэндийн байгууллагын тусламж иртэл тухайн иргэнийг түр тусгаарлах өрөөг байрны үүд хэсэгт бэлдсэн байх                                                                                                                                                   | Тусгаарлах өрөөг бэлтгэх                                                                                                                                                         | ХАБЭААлба, Эмч           |
| 8  | 1.8 |                                   | Түр тусгаарлах байранд ор, ширээ сандал, ус буцалгагч, нэг удаагийн аяга байх ба гарын цаасан алчуур, 00 цаас, гарын шингэн саван, гар халдваргүйжүүлэх уусмалаар хангах                                                                                                                      | Тусгаарлах өрөөг шаардлагатай тохижуулах зүйлсээр                                                                                                                                | ХАБЭААлба, Эмч           |
| 9  | 1.9 |                                   | Энэ түр зөвлөмжийн 7 дахь хэсэгт заасан сэжигтэй тохиолдол илэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох бүх албан тушаалтанд танилцуулж мэдээлэл өгсөн байх                                                                                                                    | Холбогдох бүх албан тушаалтанд мэдэгдэх                                                                                                                                          | Бүх хэлтэс албад         |
| 10 | 2.1 |                                   | Байгууллага, аж ахуйн нэгжүүд нь ажилтан, албан хаагчдын ажиллах хуваарийг баталж, тухайн байрны захиргаанд хүргүүлэх                                                                                                                                                                         | Ажилтан, албан хаагчдын ажиллах хуваарийг батлах                                                                                                                                 | ЗУХ                      |
| 11 | 2.2 |                                   | Ажилтан, албан хаагч, үйлчлүүлэгчдэд амны хаалтыг тогтмол зүүлгэж, гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр бүрэн хангах                                                                                                                                                                                | Амны хаалт, гар ариутгагчаар хангах                                                                                                                                              | СБХ, ХАБЭААлба, Эмч      |
| 12 | 2.3 |                                   | Улсын Онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу байгууллага, аж ахуйн нэгжүүд нь ажилтан, албан хаагчдын ажиллах хуваарьт тухай бүр зохицуулалт хийх, суудлыг 1.5-2 метр байхаар тооцож, зай барих дэглэмийг сахих                                                                           | 1.5-2 метр зай барих дэглэмийг сахих                                                                                                                                             | ХАБЭААлба, Эмч           |
| 13 | 2.4 |                                   | Байгууллага бүр ажилтан, алба хаагчдын дархлааг дэмжих, халдвараас сэргийлэх талаар санаачлагатай ажиллах                                                                                                                                                                                     | Витамин, аарц чадаргана, амны хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэгчээр хангах                                                                                                     | ЗУХ, СБХ, ХАБЭААлба, Эмч |
| 14 | 2.5 |                                   | Тандалтын зорилгоор нийт албан хаагчдыг тодорхой хуваарийн дагуу PSY шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах                                                                                                                                                                             | PSY шинжилгээнд хамруулах                                                                                                                                                        | ЗУХ, ХАБЭААлба, Эмч      |
| 15 | 2.6 |                                   | Өрөө, тасалгааны цонхыг 2-3 цаг тутамд 10-20 минут нээж, агаар сэлгэлт хийх                                                                                                                                                                                                                   | Агаар сэлгэлт хийх                                                                                                                                                               | ЗУХ, Эмч, ХАБЭААлба      |
| 16 | 2.7 |                                   | Албан хаагчдын ширээ болон хүний гар хүрдэг хэсэг бүрийг /хаалганы бариул, цахилгаан шатны товчлуур, тавиур, ус буцалгагч, шарах шүүгээ гэх мэт/ хэсгүүдэд бохирдсон тохиолдол бүрт болон 2-3 цаг тутамд халдваргүйжүүлэгч /хлор агуулсан, спиртен суурьтай/ уусмалаар арчиж халдваргүйжүүлэх | Хаалганы бариул, тавиур, ус буцалгагч, ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шатны бариул, унтраалга, цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгслийн гадаргууг халдваргүйжүүлэх | ХАБЭААлба, Эмч           |
| 17 | 2.8 |                                   | Үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүд нь яаралтай нөхцөл байдал үүссэн үед мэдээлэл хүлээн авч, удирдлагадаа шуурхай дамжуулах албан тушаалтныг томилон нэр, албан тушаал, утасны дугаарыг байрны захиргаанд өгсөн байх                                                   | Эрүүл мэндийн байгууллага, НОК-т яаралтай мэдэгдэх                                                                                                                               | ЗУХ, Эмч, ХАБЭААлба      |




|    |     |                                                         |                                                                                                                                                                               |                                                           |                        |
|----|-----|---------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|------------------------|
| 18 | 3.1 | 3. Ажилтан албан хаагчад халдвараас сэргийлэх зорилгоор | Ажилтан, алба хаагч нь иргэний үүргээ биелүүлж, Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комисс, мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, шийдвэрийг биелүүлэх, чанд мөрдөх   | УОК, НОК-оос зөвлөмжийн шийдвэрийг биелүүлэх              | Бүх хэлтэс албад       |
| 19 | 3.2 |                                                         | Хэрэв халдварын тохиолдлын ойрын болон дам хавьтал болсон, халдварын сэжигтэй шинж тэмдэг илэрсэн зэрэг үед ажилдаа ирэхгүй байх, энэ талаар удирдах ажилтанд угсаар мэдээлэх | Удирдах албан тушаалтад мэдэгдэх                          | Бүх хэлтэс албад       |
| 20 | 3.3 |                                                         | Ажилтан, алба хаагч нь бохирдсон тохиолдолд бүрт гараа зөв угааж, халдваргүйжүүлэх                                                                                            | Ариун цэврийг тогтмол сахиx                               | Ажилтан, албан хаагчид |
| 21 | 3.4 |                                                         | Ажилтан, алба хаагч нь хоолоо хувааж идэх, нэг дор бөөгнөрөх, амны хаалт зүүхгүй байх, нэг аягыг дамжуулан хэрэглэхийг хориглох                                               | Халдвар хамгааллын дэглэмийг сахиx                        | Ажилтан, албан хаагчид |
| 22 | 3.5 |                                                         | Нийтийн хэрэглээний ус буцалгагч, суурин утас, хувилагч зэрэгт нэг удаагийн бээлийтэй гараар хүрэх, гараар хүрсэн тохиолдол бүрт гараа халдваргүйжүүлэх                       | Гараа тогтмол халдваргүйжүүлэх                            | Ажилтан, албан хаагчид |
| 23 | 3.6 |                                                         | Үйлчилгээнд аль болох цахимаар харьцах, биечлэн уулзах зайлшгүй шаардлагатай тохиолдолд 2 метрээс доошгүй зайнаас 15 минутаас дээшгүй хугацаанд ярилцах                       | Хоорондын зайг 1,5м-2м зайг барьж харьцах                 | Бүх хэлтэс албад       |
| 24 | 4.1 | 4. Цэвэрлэгээ, үйлчилгээ ариутгалын талаар              | Хуваарьт байгууллагын албан хаагчдын ажил эхлэхээс өмнө болон шаардлагатай тохиолдолд ажлын байрыг угааж, цэвэрлэх, агааржуулах                                               | Цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэх                     | ЗУХ, ХАБЭААлба, Эмч    |
| 25 | 4.2 |                                                         | Хуваарьт ажлын байрандаа тогтмол байх                                                                                                                                         | Хуваарийн дагуу ажилтан албан хаагчид ажиллах             | Бүх хэлтэс албад       |
| 26 | 4.3 |                                                         | Тухайн байранд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын өрөөнүүдээр сэлгүүцэх, шаардлагагүй бол өөр ажлын өрөө, тасалгаагаар орохыг хатуу хориглох                         | Өрөө тасалгаагаар сэлгүүцэхгүй байх                       | Бүх хэлтэс албад       |
| 27 | 4.4 |                                                         | Олноороо нэг дор бөөгнөрч цугларах, ажлын байршилд хамтарч хооллох, цай уухыг хориглох                                                                                        | Ажилтан бүр хэвшил болгох                                 | ЗУХ, ХАБЭААлба, Эмч    |
| 28 | 4.5 |                                                         | Цэвэрлэгээ, үйлчилгээ хийхдээ ажлын хувцас, амны хаалт, ажлын бээлий заавал өмсөх                                                                                             | Үйлчлэгч нар                                              | ЗУХ                    |
| 29 | 4.6 |                                                         | Цэвэрлэгээ, үйлчилгээ хийсний дараа гараа заавал угааж, халдваргүйжүүлэх                                                                                                      | Гараа заавал угааж, халдваргүйжүүлэх                      | ЗУХ                    |
| 30 | 4.7 |                                                         | Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх, хэрэглэх зааврыг мөрдөх                                                                             | Халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх                           | ЗУХ, ХАБЭААлба, Эмч    |
| 31 | 5.1 |                                                         | Тухайн байранд орж ирсэн бүх хүний биеийн халууныг зайнаас хэмжиж, гадны үйлчлүүлэгчээс эрүүл мэндийн асуумж авах                                                             | Биеийн халууныг зайнаас хэмжиж, эрүүл мэндийн асуумж авах | ЗУХ, ХАБЭААлба, Эмч    |

|    |     |                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                      |                  |
|----|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|
| 32 | 5.2 | Асуумж авахдаа ерөнхий асуумжийг бүрэн авах ба асуумжаар тийм гэж хариулбал "Сэжигтэй" тохиолдол гэж үзэж, урьдчилан бэлтгэсэн тусгаарлах байранд эрүүл мэндийн байгууллагын тусламж иртэл түр тусгаарлан, хөл хорио тогтоох                                                                  | Тусгаарлах өрөөнөөс амны хаалт, нэг удаагийн хувцас, бээлий, улавч өмсөж тухайн хүнийг урьдчилан бэлтгэсэн тусгаарлах өрөөнд хүргэх                                  | ХАБЭААлба, Эмч   |
| 33 | 5.3 | Сэжигтэй гэж үзсэн хүнээс 1 метрээс дотор зайд байсан хүнийг сэжигтэй тохиолдлын хавьтал гэж үзэж 1.5-2 метрийн зай бариулан суулгах                                                                                                                                                          | Сэжигтэй тохиолдлын хавьталыг 1.5-2 метрийн зай бариулан суулгах                                                                                                     | ХАБЭААлба, Эмч   |
| 34 | 5.4 | Сэжигтэй тохиолдол илэрсэн тухай холбогдох албан тушаалтад яаралтай мэдэгдэх                                                                                                                                                                                                                  | ХӨСҮТ 119, 80086829-д дуудлага өгөх                                                                                                                                  | Бүх хэлтэс албад |
| 35 | 5.5 | Мэдээлэл авсан удирдах албан тушаалтан урьдчилан төлөвлөсний дагуу нийт байгууллагад зарлан мэдээлж, хөдөлгөөнийг зогсоох ба ХӨСҮТ-ийн 80086829, 100, Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын 11-324207 дугаарын утсанд мэдээлж, арга зүйн зөвлөгөө авч, холбогдох арга хэмжээг авч ажиллах | Томилгогдсон ажилтан тусгаарлах өрөөнөөс амны хаалт, нэг удаагийн хувцас, бээлий, улавч өмсөж тухайн хүнийг урьдчилан бэлтгэсэн тусгаарлах өрөөнд хүргэх, байрлуулах | ХАБЭААлба, Эмч   |
| 36 | 5.6 | Мэргэжлийн байгууллагын албан ёсны зөвшөөрөл иртэл хөл хориог үргэлжлүүлэх                                                                                                                                                                                                                    | Мэргэжлийн байгууллагатай холбогдох                                                                                                                                  | Бүх хэлтэс албад |
| 37 | 5.7 | Хөл хорио тогтоосон үед тусгаарлалтад орсон иргэн, албан хаагчдад яаралтай тусламж шаардлагатай бол Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын 11324207 дугаарын утсанд мэдээлж тусламж дуудах                                                                                                 | 11324207 дугаарын утсанд мэдээлж тусламж дуудах                                                                                                                      | ХАБЭААлба, Эмч   |
| 38 | 5.8 | Сэжигтэй тохиолдлыг эмнэлэгт шилжүүлсний дараа нэгдсэн байранд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар эцсийн халдваргүйтгэл хийлгэж, хэвийн үйл ажиллагааг эхлүүлэх                                                                                                                  | Мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэл хийлгэх                                                                                                                      | ХАБЭААлба, Эмч   |

**5. Сэжигтэй тохиолдлын үед авах арга хэмжээ**

Жич: Бүх хэлтэс, алба, баазууд сар бүрийн 25-ны өдөр төлөвлөгөөний биелэлтийг цаасан болон цахим хэлбэрээр Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлж байх

ХЯНАСАН:  Д.ОЮУНЧИМЭГ  
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:  Б.РЭНЦЭНХАНД  
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР